


**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: “Монгол шуудан” ХК УБГД: 9012001026 ҮЦК: MNP, MN00MNP05412 Утас: 976 70078918, 976 11330788		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүргүүлсэн огноо	“Ниямазон Аудит” ХХК		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	99,586,363 (ерэн есөн сая таван зуун наян зургаан мянга гурван зуун жаран гурав) ширхэг		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: ТУЗ-нийн нарийн бичгийн дарга Д.Цэцгээ Хянасан: Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн Дэд захирал Н.Хосбаяр		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2024.01.01)	Эцсийн үлдэгдэл (2024.12.31)
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө	27,571,962,930.20	25,540,229,689.87
	Эргэлтийн бус хөрөнгө	10,805,095,264.30	11,489,340,143.01
	Нийт хөрөнгө	38,377,058,194.50	37,029,569,832.88
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
	Өр төлбөрийн нийт дүн	12,229,681,716.05	11,404,904,364.46
	Эздийн өмч	26,147,376,478.45	25,624,665,468.42
	Нийт өр төлбөр ба эздийн өмч	38,377,058,194.50	37,029,569,832.88
Орлогын тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2024.01.01)	Эцсийн үлдэгдэл (2024.12.31)
	Борлуулалтын орлого (цэвэр)	19,369,578,379.77	23,894,295,918.89
	Борлуулалтын өртөг	21,526,001,245.47	21,896,067,590.24
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	598,858,309.48	497,217,900.90
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,763,883,195.83	2,048,302,996.58
	Бусад	5,393,800,778.03	-282,537,513.96
	Татвар төлөхийн өмнөх ашиг	2,107,851,485.36	168,605,718.92
	Орлогын татварын зардал	140,136,455.05	32,587,849.41
	Татварын дараах ашиг	1,967,715,030.31	136,017,869.51
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2024.01.01)	Эцсийн үлдэгдэл (2024.12.31)
	Эздийн өмч	9,958,636,300.00	9,958,636,300.00
	Хуримтлагдсан ашиг	6,556,222,661.62	6,033,511,651.59

Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (2024.01.01)	Эцсийн үлдэгдэл (2024.12.31)
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,505,920,850.98	-4,056,199,259.02
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-1,517,624,299.33	-1,235,669,000.05
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-221,219,675.23	-586,92,851.70
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-3,237,431,731.03	-6,401,314,482.45

1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	Үндэсний аудитын газраас өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.
1.2	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/
	 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР Засгийн газрын IV байр, Баян 100079.3 Чулуутай дотроо "Улаанбаатар хот 15.000 Утас: 78 04 37 Факс: 7878-611 Ж 42 30, Цахилгаан сувгаар холбогдсон гэрээтэй, Цахилгаан сувгаар холбогдсон гэрээтэй <u>0085.03.13 № 07/0062</u> танил _____ нэмэлт _____ Өөрчлөлтгүй дүгнэлт МОНГОЛ ШУУДАН ХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ТЭЛМЭН ТАНАА Бусад асуудлын хэсэг Компани нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. Удирдлага болон Засаглал эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэм зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ. Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага Төрийн аудитын байгууллага захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүрэлдэх явцад эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дэд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь захиран эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг. САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  НАРАНЧИМЭГ АТЗ 5002 № 1100 10.10.2024
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл
2.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/ Эргэлтийн харьцаа=ЭХ/БХӨТ=2.24 Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар=(БМ+БХХО+Авллага)/БХӨТ=1.37 Өрийн харьцаа=Нийт ӨТ/НХ=0.30
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт Өр төлбөр эздийн өмчийн харьцаа=Нийт ӨТ/ЭӨмч=44.5% Нийт хөрөнгийн өгөөж=БО/цэвэр/Нийт хөрөнгө= 0.64

2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Дараах хүчин зүйлсийн нөлөөлөл үргэлжилж байна. - Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэгч, хүргэлтийн компанийн тусгай зөвшөөрөл, үйл ажиллагааны ялгаатай байдал байхгүйгээс Монгол улсын нэгдэн орсон олон улсын конвенц хэрэгжихгүй байх, цахим худалдааны бараа бүтээгдэхүүн карго нэрээр хяналтгүй, татваргүй албан бусаар улсын хилээр нэвтэрч байгаа нь далд эдийн засгийг үүсгэж, тэгш бус бизнесийн орчныг үүсгэж байна. - Орос-Украины дайны нөлөөгөөр ОХУ-д тавигдсан хоригууд нь төлбөр тооцоо, транзит шуудан тээвэрт сөргөөр нөлөөлж орлогын тасалдлыг үүсгэж байна. Хариу арга хэмжээ: - Тасалдаж буй бизнесийн үйлчилгээний орлогыг бусад үйлчилгээний орлогоос нөхөх - Үйлчилгээний тарифуудыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, - Хууль эрх зүйн шинэчлэлийг бүрдүүлэх
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Байхгүй
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	Байхгүй
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.	
4.	Цалин урамшууллын мэдээлэл	
	Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 онд цалин болон бусад зардалд 193.5 сая төгрөг зарцуулсан байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ХЭ-23/02 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн сарын цалинг доорх дүнгээр баталсан. ТУЗ-ийн дарга-1,500,000 төг ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга-1,400,000 төг ТУЗ-ийн бусад гишүүд- 1,300,000 төг	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	Засаглалын бүтэц, үйл ажиллагаа <u>Хувьцаа эзэмшигчдийн хурал</u> Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагт компанийн 4 давхрын “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд зохион байгуулагдав. Хурлаас гарсан шийдвэрүүд: - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав. - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлав. - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилов. <u>Төлөөлөн удирдах зөвлөл</u> “Монгол шуудан” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон төлөөлөн удирдах зөвлөл удирддаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 6 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүнтэй. 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ХЭ-чдийн ээлжит хурлаар Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт орсоноор ТУЗ-ийн дэргэдэх хороодын нэршилд өөрчлөлт орж, Аудитын, Нэр дэвшүүлэх (засаглал), Цалин урамшуулал (стратег, эрсдэл)-ын хороог ажиллууллаа. Тайлант хугацаанд ТУЗ нь 90.8 хувийн дундаж ирцтэйгээр 12 удаа /эчнээ, цахим, танхим/ хуралдаж, доор дурдсан чиглэлээр 25	

асуудлуудыг хэлэлцэж, 21 тогтоол, 4 тэмдэглэлээр шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.

Компанийн засаглал:

Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд “Компанийн засаглалын кодексыг “Монгол шуудан” ХК-нд хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийг батлан, хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд дараах журмуудыг баталсан. Үүнд

- ✓ ТУЗ-ийн болон хороодын үйл ажиллагааны шинэчилсэн журам,
- ✓ “Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам”,
- ✓ “Монгол шуудан” ХК-ийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”

Санхүүгийн зохицуулах хорооноос үнэлдэг “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний баталгаажуулалтаар 2023 онд 76.3 хувийн үзүүлэлттэй байсан бол 2024 онд 83 хувьд хүрч компанийн дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм журам, зааврыг засаглалын зарчимд нийцүүлэн баталгаажуулж, хэрэгжүүлж ажиллав. Цаашид компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах, бодлогын бичиг баримт боловсруулах, хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох хөтөлбөрийг боловсруулахаар зорин ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдал:

Компани Шилэн дансны тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 62 нэр төрлийн мэдээлэл буюу Худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, хүний нөөц, төсөв санхүүтэй холбоотой мэдээллүүдийг <https://shilendans.gov.mn/>, <https://www.tender.gov.mn/mn>, <https://mse.mn/mn>, болон өөрийн байгууллагын <https://www.mongolpost.mn/> сайтад байршуулан ажиллах үүрэгтэй бөгөөд тайлант хугацаанд мэдээллүүд бүрэн, ил тод байршин хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудад мэдээллийг хүргэсэн.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын жилийн эцсийн байдлаарх хууль, журам болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн судалгаагаар 2023 онд 90.9 хувийн хэрэгжилттэй гарч байсан бол 2024 онд 100 хувь болгож, мэдээллийн ил тод байдал, нээлттэй хувьцаат компанийн үүргийн хэрэгжилтийг ханган ажиллав.

Тайлант хугацаанд ажилласан ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл:


1. Даваахүү **НАРАНГЭРЭЛ**
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга
2. Даваасамба **ДЭЛГЭРМАА**
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга
3. Даваадорж **БАЛЖИННЯМ**
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны гишүүн
4. Батаа **БАТЦЭЦЭГ**
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн
5. Одончимэд **ОДБАЯР**
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга
6. Батбилэг **ЗОЛБОО**
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
7. Банзрагч **ГАНБААТАР**
Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн
8. Дарамбазар **БАЛДОРЖ**
Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн
9. Чүлтэм **АМАРБААТАР**
Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн

Удирдлагын баг

1. Гэрэлт **ТЭЛМЭН** - Гүйцэтгэх захирал
2. Нанзад **ХОСБАЯР** - Олон улсын бизнес хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал
3. Даваахүү **БАТТУЛГА** – Салбар удирдлагын газрын захирал
4. Орсоо **САРАНГЭРЭЛ** – Улс хоорондын шуудангийн газрын захирал
5. Ганболд **ГАНЧИМЭГ** – Санхүү, төлөвлөлтийн газрын захирал
6. Очирлахва **ОТГОНБАЯР** – Хүний нөөц, үйл ажиллагааны газрын захирал

7. Санжжав СУВДАНГЭРЭЛ – Мэдээллийн технологийн газрын захирал
8. Алтангэрэл НАНДИН-ЭРДЭНЭ – Шуудан, логистикийн газрын захирал
9. Эрдэнэтүяа ЭНХ-АМГАЛАН – Бизнес хөгжлийн газрын захирал

Компанийн бүтэц




6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл


Компанийн үйл ажиллагаанд дараах эсдлүүд тулгарч байна. Үүнд:

- Үнийн өсөлт, зардлын өсөлт
- УБ хот болон хил дамнасан цахим худалдааны хүчтэй өрсөлдөөн, албан бус шуудангийн сувгийн тэлэлт
- Хүний нөөцийн тогтворгүй байдал, ур чадвартай ажилтнуудын хомсдол
- Мэдээлэл технологийн чадавх сул, технологийн хоцрогдол
- Хөрөнгө оруулалт, худалдан авалтын хуулийн хязгаарлалт
- Бүх нийтийн үйлчилгээний үүргийг хүлээдэг ч төрөөс татаас тогтвортой бус, санхүүжилт байхгүй

7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэр эзэмшлийн хувь нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

Тайлант хугацаанд Монголын хөрөнгийн биржийн I ангилалд багтсан амжилтаа бататгаж, хувьцаа эзэмшигчдийн тоо 3,390-д хүрч 2024 оны туршид 0.5 тэрбум төгрөгийн 780 мянган ширхэг хувьцаа Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан байна.



8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээ Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.	
9.	Ногдол ашгийн мэдээлэл 2023 оны ногдол ашгийг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100% олгосон. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 25/02 дугаар тогтоолоор компанийн 2024 оны цэвэр ашгаас 73.2 хувь буюу нэгж хувьцаанд 1.0 (нэг) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2025 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөр тогтов.	
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл - Компанийн дотоод үйл ажиллагааг цахим болгох, цахим архив, цахим удирдлагын тогтолцоог бий болгох ажлын хүрээнд Цааснаас Цахим, И-оффис /DOCMINE/ системийг хэрэгжүүлж эхэллээ. - Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн 50 ширхэг модыг тарьж 30 ажилтнуудыг хамруулан оролцсон. - Нийгмийн хариуцлагын хүрээнд НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг үйл ажиллагаандаа шат дараатай нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд #Зохистой Хэрэглээг нийт шуудангийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилготой дараах “НӨЛӨӨЛЛИЙН АЯН” хэрэгжүүлж ажилласан. Үүнд: - Цаасны хэрэглээг бууруулж, байгаль эхээ хамгаалай. /Цааснаас цахимруу/ - Цахилгаан эрчим хүчээ хэмнэж хүлэмжийн хийг бууруулах. /Өдрийн цагаар гэрлээ унтрааж, ашиглалтгүй үед тогноос салгах/ - Усны хэрэглээг багасгаж, цэвэр усны хомсдолоос сэргийлэх /гар угаах, 00 ашиглахдаа бага ус зарцуулах гэх мэт/ - Донорын үндэсний төвөөс цус хандивлах аянд нэгдэж Монгол шуудан ХК-аас 20 ажилтан цусаа хандивлаж, Улаанбурханы халдвараас сэргийлэх сургалтад 30 ажилтан тус тус хамрагдав. - Ажилтны нийгмийн халамж, амьдралын нөхцөл сайжруулах ажлын хүрээнд Шуудангийн ажилтны үйлдвэрчний эвлэл, байгууллага хооронд байгуулсан хамтын гэрээний дагуу 21 ажилтанд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлээ.	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Г.Тэлмэн Албан тушаал: “Монгол шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг:  (Тамга, тэмдэг) 		Овог, нэр: Г.Ганчимэг Албан тушаал: “Монгол шуудан” ХК-ийн Санхүү төлөвлөлтийн газрын захирал Гарын үсэг:  (Тамга, тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Д.Цэцгээ Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Гарын үсэг:  Огноо: 2025.04.30		